



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН  
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2019 оны 12 дугаар сарын 9-ний өдөр  
Хурал болсон газар: Гадаад харилцааны яам

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 9 асуудлуудыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэлтэй УЗ-ийн гишүүд танилцаж, санал нэгтгэйгээр батлав.
2. Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт болон Компакт гэрээний санхүүжилтийн хөрөнгөөр 2020.01.01-нээс 2020.12.31-ний хооронд тус тус хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санал нэгтгэйгээр батлав.
3. Монголын МСС-ийн 2020 оны нэгдүгээр улирлын санхүүжилтийн төлөвлөгөөг хэлэлцэж, Монголын МСС-ийн 2020 оны нэгдүгээр улирлын санхүүжилтийн төлөвлөгөөг санал нэгтгэйгээр баталж, МСК-д уламжлагаар шийдвэрлэв.
4. Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө болон Аудитын төлөвлөгөөний төслүүдийн талаар УЗ-ийн гишүүд хэлэлцээд, АНУ-ын МСК-аас эдгээр төлөвлөгөөг тус тус баталгаажуулсны дараа Удирдах зөвлөлийн гишүүдээс бичгэн зөвшөөрөл авч батлуулахаар шийдвэрлэв.
5. Дотоод аудитын стратегийн ба 2020 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, Дотоод аудитын стратегийн ба 2020 оны төлөвлөгөөг гишүүд санал нэгтгэйгээр батлав.
6. Монголын МСС-ийн Аудитын хорооны дүрмийн төслийг хэлэлцэж, Аудитын хорооны дүрмийг санал нэгтгэйгээр батлав.
7. Монголын МСС-ийн Худалдан авах ажиллагааны захирлыг сонгон шалгаруулсан тайланг танилцуулсны дараа Худалдан авах ажиллагааны захирлыг сонгон шалгаруулсан тайланг санал нэгтгэйгээр батлав.
8. Баруун эх үүсвэрийн төслийн цахилгаан болон дулаан хангамжийн талаар Монголын МСС-ийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал танилцуулав.
9. Удирдах зөвлөлийн зарим гишүүд Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах урьдчилсан болзолт нөхцлүүдийн хэрэгжилтийн явц болон манай Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар товч мэдээлэл хийв.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН